

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	20
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТББ	Төрийн бус байгууллага
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ  
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
Ц.ГАНЧИМЭГ ТАНАА

2020.02.27 № 06/616  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ц.Ганчимэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн бараа материалын тайлан, бараа ажил үйлчилгээний худалдан авалт, хувь хүний орлогын татварын суутгалыг хийх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-наас 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 1/43 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжил, хамгааллын талаарх Засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх замаар амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөгжлийг дэмжих.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 тоот “Журам батлах тухай” тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 тоот “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 тоот “Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол.
- ХНХЯамны сайдын 2019 оны А/83 тоот тушаалын дагуу “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан” байгуулан тус газар сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулахаар заасан байна.
- Ази номхон далайн бүсийн орнуудын IV конгрессыг 2019 оны 07 дугаар сарын 2,3 нд Улаанбаатар хотноо зохион байгуулсан.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “ACOLOUS” программ хангамж ашигладаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,382,665.5 мянган төгрөгөөс тооцон 47,653.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон гүйцэтгэлийн үе шатанд хэвээр үлдээн баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 66,897.9 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8.0	9.2	1.2
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	4,593.0	10,109.5	5,516.5
Үндсэн хөрөнгө	6,724,444.9	6,785,825.1	61,380.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,729,045.9</b>	<b>6,795,943.8</b>	<b>66,897.9</b>
Өр төлбөр		459.6	(459.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,729,045.9	6,795,943.8	66,897.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,729,045.9</b>	<b>6,795,943.8</b>	<b>67,357.5</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Ази номхон далайн бүсийн орнуудын IV конгрессын хуралд оролцогчдод тараах материал дутуу тараагдсанаас 294 ширхэг 5,820.0 мянган төгрөгийн танилцуулга үлдэгдэлтэйгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө өссөн нь улсын төсвийн хөрөнгөөр 2 ширхэг тусгай зориулалтын авто машиныг 240,500.0 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 980.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 308.0 мянган төгрөгөөр нийт 241,788.0 мянган төгрөгөөр худалдан авснаас шалтгаалжээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 431 тоот тогтоолын дагуу Олон улсын нисэх буудлын төсөлд бүртгэлтэй 67,900.0 мянган төгрөгийн 1 ширхэг авто машин, Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд ХНХЯмнаас 41,098.0

мянган төгрөгийн сүлжээний тоног төхөөрөмж нийт 108,998.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө өссөн нь 770.0 мянган төгрөгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн "Гүүк софт" ХХК-ийн Axplorer программыг худалдан авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,795,943.8 мянган төгрөг болж 66,897.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 2,339,805.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,339,805.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсан байна.

ХНХЯ-ны сайдын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/39 тоот тушаалаар 250,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд нэмж зарцуулахаар шийдвэрлэж, уг төсвөөр тусгай зориулалтын 2 ширхэг авто машиныг худалдан авч бүртгэжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,320,817.1 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь төсвийг 19,045.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, улсын төсөвт татан төвлөрүүлжээ.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулахад бичиг хэргийн зардал 4,517.3 мянган төгрөгөөр хэтэрсэн нь олон улсын хурлаас шалтгаалан тараах материал нэмж хэвлүүлснээс үүссэн ба хангамж, бараа материалын бүлгийн дүнгээр хэтрээгүй болно.

Хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээнд 1,170,000.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,159,832.6 мянган төгрөгийг зарцуулсан нь Хөдөлмөр эрсдэлтийг дэмжих дэд сангийн санхүүжилтэд зарцуулагдсан.

**Нэмэлт төсөв:** Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгосон 348.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн шилжүүлжээ.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 17,973.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,898.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 16,075.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

- Тайлант хугацаанд шатах, тослох материалын нярвын тайланг бэлтгэхдээ авто машины шатахууны хэтрэлт, хэмнэлтийг сар тутам тооцоогүй 1,607.9 мянган төгрөг, нярвын тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй 123.6 мянган төгрөг, шатахууны урамшууллыг орлогод бүртгээгүй 166.7 мянган төгрөг, нийт 1,898.2 мянган төгрөгийн зөрчилтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны



хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалт, УСНББОУС 1.29 дүгээрт "Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага хүргүүлэх.

Аудитаар илэрсэн 16,075.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллийг байршуулахаас 143 мэдээллийг байршуулж, 69 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг огт байршуулаагүй, 2 мэдээлэл хугацаа болоогүй хүлээгдэж байна.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд нийт 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 17,973.8 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 47,653.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Бараа материалын тайланг тайлант хугацаанд нэр төрөл, ангиллын дагуу сар тутам бэлтгээгүй нийт 10,109.5 мянган төгрөгийн бараа материал, мөн аж ахуйн материалаас хүчин төгөлдөр биш шаардах хуудсаар 255.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гаргасан зэрэг нийт 10,364.8 мянган төгрөгийн зөрчил байна. Эдгээр нь иж бүрэн байх, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, “Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна” гэж заасныг зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Бараа материалын орлого, зарлагын бүртгэлд тавих хяналт сул, холбогдох хууль тогтоомж, зааврыг мөрдөөгүй байх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Бараа материалын тайланг сар бүр нэр төрөл ангиллын дагуу бэлтгэж, УСНББОУС-12, болон хууль тогтоомж, журам, зааврыг мөрдөж ажиллах.

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг биелүүлж, зөрчлийг цаашид гаргахгүй ажиллана.

### 3.2 Зардлын данстай холбоотой асуудал

#### 3.2.1 Илрүүлэлт:

Худалдан авалт хийхдээ 5,251.3 мянган төгрөгийн цахим төлбөрийн Е-баримтын бүрдлийг ханган ажиллаагүй. Энэ нь үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Маягт заавар батлах тухай" тушаалын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм "гэж заасныг зөрчсөн.

#### 3.2.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаагүй байх, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хэрэгжихгүй байх.

#### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын хуулийг хэрэгжүүлж бэлтгэн нийлүүлэгчдээс цахим е баримтыг ханган ажиллах.

#### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цахим Е-баримтын бүрдлийг ханган ажиллаж харилцагч байгууллагуудтай тулган баталгаажуулна.

### 3.3 Зардлын данстай холбоотой асуудал:

#### 3.3.1 Илрүүлэлт:

Цалин хөлс олгохдоо 40 ажилтны 459.6 мянган төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн илүү тооцсон нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй ба Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 3.3.2 Эрсдэл:

Хувь хүний орлогын албан татварын хууль хэрэгжихгүй байх, цалингийн тооцоолол зөрүүтэй тооцоологдох.

#### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хөнгөлөлтийн тооцооллын зөрүүг ажилчид, албан хаагчдад буцаан олгож, цалин хөлсний тооцооллыг татварын хууль, тогтоомжийн дагуу алдаагүй хийж гүйцэтгэх.

#### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,601,000.00</u></b>	<b><u>10,118,741.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	8,000.00	9,247.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	8,000.00	9,247.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	8,000.00	9,247.00
31213	Арилжааны банк дахь харилцах	8,000.00	9,247.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>4,593,000.00</b>	<b>10,109,494.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>4,593,000.00</b>	<b>10,109,494.00</b>
35410	Бичиг хэргийн материал	4,593,000.00	9,229,448.00
35420	Аж ахуйн материал		595,850.00
35470	Бусад хангамжийн материал		284,196.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>6,724,444,852.54</u></b>	<b><u>6,785,825,026.83</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,724,444,852.54	6,785,825,026.83
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>6,656,682,152.54</b>	<b>6,718,456,160.20</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,558,034,247.00	6,558,034,247.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(247,490,450.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		308,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(17,683,333.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	79,654,315.48	120,752,327.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,984,713.21)	(27,807,127.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,216,056.96	33,196,056.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,777,738.68)	(26,926,494.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,080,635.00	14,388,635.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,540,650.01)	(4,407,700.01)
39217	Ном	8,000,000.00	8,000,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	67,762,700.00	67,368,866.63
39303	Бусад биет бус хөрөнгө	67,762,700.00	68,532,700.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,163,833.37)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>6,729,045,852.54</u></b>	<b><u>6,795,943,767.83</u></b>
41224	Төслийн зээл	-	-
41225	Бусад гадаад эх үүсвэрээс	-	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	459,600.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		459,600.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>6,729,045,852.54</u></b>	<b><u>6,795,484,167.83</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,729,045,852.54	6,795,484,167.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,474,849,925.14	1,474,849,925.14
51101	Өмч: - төрийн	1,474,849,925.14	1,474,849,925.14
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	47,199,920.46	113,638,235.75
51210	Өмнөх үеийн үр дүн		47,199,920.46
51220	Тайлант үеийн үр дүн	47,199,920.46	66,438,315.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,206,996,006.94	5,206,996,006.94
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>6,729,045,852.54</u></b>	<b><u>6,795,943,767.83</u></b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>325,149,100.00</b>	<b>2,449,563,425.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>109,410,425.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>109,410,425.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	<b>109,057,225.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	59,213.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө		108,998,012.00
120011	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал		353,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>325,149,100.00</b>	<b>2,340,153,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>325,149,100.00</b>	<b>2,339,805,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	325,149,100.00	2,339,805,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>348,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		348,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>277,949,179.53</b>	<b>2,383,125,109.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>277,949,179.53</b>	<b>2,383,125,109.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>266,580,635.10</b>	<b>2,363,631,237.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>83,873,925.76</b>	<b>518,191,859.42</b>
210101	Үндсэн цалин	83,873,925.76	518,191,859.42
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>9,989,754.80</b>	<b>65,257,972.43</b>
210201	Тэтгэврийн даатгал	6,812,234.14	46,107,650.64
210202	Тэтгэмжийн даатгал	851,529.27	5,165,142.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	681,223.41	4,132,114.38
210204	Ажилгүйдлийн даатгал	149,524.36	895,733.13
210205	Эрүүл мэндийн даатгал	1,495,243.62	8,957,331.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>50,984,039.87</b>
210301	Гэрэл, цахилгаан		22,620,092.00
210302	Түлш, халаалт		14,561,476.64
210303	Цэвэр, бохир ус		13,802,471.23
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>36,922,207.00</b>	<b>94,043,737.74</b>
210401	Бичиг хэрэг	27,535,599.00	10,130,363.00
210402	Тээвэр, шатахуун	2,750,000.00	5,411,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		10,027,183.74
210404	Ном, хэвлэл	-	48,140,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,636,608.00	20,335,191.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>84,218,338.00</b>	<b>76,482,950.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	611,350.00	49,416,000.00

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,024,050.00
210604	Урсгал засвар	83,606,988.00	26,042,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,732,000.00</b>	<b>15,312,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,732,000.00	15,312,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>32,698,420.00</b>	<b>1,224,458,479.81</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,115,600.00	1,219,839,559.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		106,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,582,820.00	990,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,145,989.54</b>	<b>318,900,198.71</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,510,910.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		28,724,361.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,635,079.54	290,175,837.71
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,368,544.43</b>	<b>19,493,871.73</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>100,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>11,368,544.43</b>	<b>19,393,871.73</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,368,544.43	19,393,871.73
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>47,199,920.47</u></b>	<b><u>66,438,315.29</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>47,199,920.47</u></b>	<b><u>66,438,315.29</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>325,149,100.00</b>	<b>2,340,212,213.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>59,213.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	59,213.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	59,213.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	59,213.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>325,149,100.00</b>	<b>2,340,153,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	325,149,100.00	2,339,805,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	325,149,100.00	2,339,805,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>348,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		348,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>325,141,100.00</b>	<b>2,097,652,966.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>325,141,100.00</b>	<b>2,097,652,966.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>313,772,555.57</b>	<b>2,078,159,094.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	83,873,925.64	517,732,258.23
210101	Үндсэн цалин	64,812,484.64	388,579,246.23
210102	Нэмэгдэл	9,372,593.00	85,741,432.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,688,848.00	43,411,580.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>9,989,754.93</b>	<b>65,257,972.43</b>
210201	Тэтгэврийн даатгал	9,989,754.93	49,995,584.19
210202	Тэтгэмжийн даатгал		3,985,032.14
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,072,370.94
210204	Ажилгүйдлийн даатгал		1,851,049.39
210205	Эрүүл мэндийн даатгал		7,353,935.77
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>50,984,039.87</b>
210301	Гэрэл, цахилгаан		22,620,092.00
210302	Түлш, халаалт		14,561,476.64
210303	Цэвэр, бохир ус		13,802,471.23
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>44,428,057.00</b>	<b>95,010,629.74</b>
210401	Бичиг хэрэг	16,623,099.00	10,419,811.00
210402	Тээвэр, шатахуун	2,750,000.00	5,411,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		10,027,183.74
210404	Ном, хэвлэл	6,250,000.00	48,140,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		342,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,804,958.00	20,670,235.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>107,299,488.00</b>	<b>76,482,950.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,876,500.00	49,416,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,024,050.00
210604	Урсгал засвар	77,422,988.00	26,042,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,732,000.00</b>	<b>15,312,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,732,000.00	15,312,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>48,158,420.00</b>	<b>1,228,654,883.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,260,600.00	1,224,035,963.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		106,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,897,820.00	990,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,290,910.00</b>	<b>28,724,361.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,290,910.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		28,724,361.00



Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,368,544.43</b>	<b>19,493,871.73</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>100,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>11,368,544.43</b>	<b>19,393,871.73</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,368,544.43	19,393,871.73
213304	Хөрөнгийн	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>8,000.00</b>	<b>242,559,247.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>242,558,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>242,558,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>242,558,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	242,558,000.00
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>-</b>
226001	Гадаад эх үүсвэрээр	-	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>≡</b>	<b>(242,558,000.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>8,000.00</b>	<b>1,247.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>8,000.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>8,000.00</b>	<b>9,247.00</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	5,206,996,006.94	-	5,206,996,006.94
C07	Тайлант үеийн үр дүн	1,474,849,925.14	-	47,199,920.46	1,522,049,845.60
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	47,199,920.46	6,729,045,852.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	47,199,920.46	6,729,045,852.54
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	66,438,315.29	66,438,315.29
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	113,638,235.75	6,795,484,167.83

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8,000.00	8,000.00	
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,339,805,000.00</b>	<b>2,320,817,094.27</b>	<b>(18,987,905.73)</b>	<b>99.2</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,339,805,000.00</b>	<b>2,320,817,094.27</b>	<b>(18,987,905.73)</b>	<b>99.2</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,338,055,000.00</b>	<b>2,320,717,094.27</b>	<b>(17,337,905.73)</b>	<b>99.3</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>530,371,500.00</b>	<b>517,732,258.23</b>	<b>(12,639,241.77)</b>	<b>97.6</b>
210101	Үндсэн цалин	409,156,300.00	388,579,246.23	<b>(20,577,053.77)</b>	95.0
210102	Нэмэгдэл	87,142,700.00	85,741,432.00	<b>(1,401,268.00)</b>	98.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,072,500.00	43,411,580.00	<b>9,339,080.00</b>	127.4
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,644,100.00</b>	<b>65,257,972.43</b>	<b>(1,386,127.57)</b>	<b>97.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	45,560,200.00	49,995,584.19	<b>4,435,384.19</b>	109.7
210202	Тэтгэмжийн даатгал	5,271,000.00	3,985,032.14	<b>(1,285,967.86)</b>	75.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,705,200.00	2,072,370.94	<b>(1,632,829.06)</b>	55.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,565,800.00	1,851,049.39	<b>285,249.39</b>	118.2
210205	Эрүүл мэндийн даатгал	10,541,900.00	7,353,935.77	<b>(3,187,964.23)</b>	69.8
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>52,118,100.00</b>	<b>50,984,039.87</b>	<b>(1,134,060.13)</b>	<b>97.8</b>
210301	Гэрэл, цахилгаан	20,975,000.00	22,620,092.00	<b>1,645,092.00</b>	107.8
210302	Түлш, халаалт	16,112,500.00	14,561,476.64	<b>(1,551,023.36)</b>	90.4
210303	Цэвэр, бохир ус	15,030,600.00	13,802,471.23	<b>(1,228,128.77)</b>	91.8
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>95,098,400.00</b>	<b>95,010,629.74</b>	<b>(87,770.26)</b>	<b>99.9</b>
210401	Бичиг хэрэг	5,902,500.00	10,419,811.00	<b>4,517,311.00</b>	176.5
210402	Тээвэр, шатахуун	6,731,900.00	5,411,000.00	<b>(1,320,900.00)</b>	80.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,093,300.00	10,027,183.74	<b>(66,116.26)</b>	99.3
210404	Ном, хэвлэл	49,000,000.00	48,140,000.00	<b>(860,000.00)</b>	98.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		342,400.00	<b>342,400.00</b>	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,370,700.00	20,670,235.00	<b>(2,700,465.00)</b>	88.4
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>76,596,000.00</b>	<b>76,482,950.00</b>	<b>(113,050.00)</b>	<b>99.9</b>
	Багаж техник хэрэгсэл	49,416,000.00	49,416,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	1,024,050.00	<b>524,050.00</b>	204.8
210604	Урсгал засвар	26,680,000.00	26,042,900.00	<b>(637,100.00)</b>	97.6
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,394,100.00</b>	<b>15,312,000.00</b>	<b>(82,100.00)</b>	<b>99.5</b>
210702	Дотоод албан томилолт	15,394,100.00	15,312,000.00	<b>(82,100.00)</b>	99.5

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,473,071,300.00</b>	<b>1,471,212,883.00</b>	<b>(1,858,417.00)</b>	<b>99.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,467,349,500.00	1,465,823,963.00	<b>(1,525,537.00)</b>	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	3,500,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	232,200.00	106,920.00	<b>(125,280.00)</b>	46.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,600.00		<b>(163,600.00)</b>	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	22,000.00	<b>(44,000.00)</b>	33.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,760,000.00	1,760,000.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>28,761,500.00</b>	<b>28,724,361.00</b>	<b>(37,139.00)</b>	<b>99.9</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,761,500.00	28,724,361.00	<b>(37,139.00)</b>	99.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,750,000.00</b>	<b>100,000.00</b>	<b>(1,650,000.00)</b>	<b>5.7</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,750,000.00</b>	<b>100,000.00</b>	<b>(1,650,000.00)</b>	<b>5.7</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,750,000.00	100,000.00	<b>(1,650,000.00)</b>	<b>5.7</b>
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,339,805,000.00</b>	<b>2,320,818,341.27</b>	<b>(18,986,658.73)</b>	<b>99.2</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,339,805,000.00</b>	<b>2,320,759,128.27</b>	<b>(19,045,871.73)</b>	<b>99.2</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,339,805,000.00	2,320,759,128.27	<b>(19,045,871.73)</b>	<b>99.2</b>
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	<b>59,213.00</b>	<b>59,213.00</b>	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	8,000.00	<b>8,000.00</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	9,247.00	<b>9,247.00</b>	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>35</b>	<b>35</b>	-	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	6	6	-	<b>100.0</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	29	29	-	<b>100.0</b>

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>348,000.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>348,000.00</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		348,000.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	35.00	35.00
Удирдах ажилтан	6.00	6.00
Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00
Үйлчлэх ажилтан		

## 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.</i>	Аудитын код:
2019			САГ-2020/230/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цахим системд Е-баримтын бүрдэл хангаагүй 5,152.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.	5,251.3	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Э.Хаш-Эрдэнэ
2	Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг тооцохдоо 40 ажилтанд 459,6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.	459.6	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Э.Хаш-Эрдэнэ
3	Няравын тайланг сар болгон, нэр төрөл тус бүрээр хийж бэлтгээгүй. Мөн нийт 10,109.5 мянган төгрөгийн бараа материалыг нэр төрөл, ангиллаар нь тайлагнаагүй, 255,3 мянган төгрөгийн шаардах засвартай хүчин төгөлдөр биш баримтаар зарлагын гүйлгээ хийсэн зэрэг зөрчил илэрсэн.	10,364.8	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Э.Хаш-Эрдэнэ
4	Шатахууны тайланд орлого аваагүй 166,7 мянган төгрөг, хэтрэлт хэмнэлт тооцоогүй 1,607.9	1,898.2	Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Э.Хаш-Эрдэнэ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

мянган төгрөг , эхний үлдэгдэл 123,6 мянган төгрөгөөр зөрүүтэй зөрчлүүд илэрсэн.				
<b>НИЙТ ДҮН</b>	<b>17,973.9</b>			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 02 дугаар сарын 28

№ 02/15

Улаанбаатар хот

СМГ-2020/030/СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд шатах, тослох материалын авто машины шатахууны хэтрэлт, хэмнэлтийг сар тутам тооцоогүй, нярвын тайланг 1,898.2 мянган төгрөгийн зөрүүтэй бэлтгэсэн зөрчилтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авто машины шатахууны хэтрэлт, хэмнэлтийг сар бүр тооцох
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Ц.Ганчимэг Ерөнхий нягтлан бодогч Ж.Хаш-Эрдэнэ нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ

*П.Чанцалдулам* П.ЧАНЦАЛДУЛАМ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-НИЙ  
АУДИТОР

*Ч.Эрдэнэжав* Ч.ЭРДЭНЭЖАВ

**ЗӨВШӨӨРСӨН:**

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ  
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

*Ц.Ганчимэг* Ц.ГАНЧИМЭГ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

*Ж.Хаш-Эрдэнэ* Ж.ХАШ-ЭРДЭНЭ

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтныг хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*